

Мэндчилгээ

Эцэг эхчүүд та бүхэндээ энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Бидний зохион байгуулсан Summer of Code 2025 зуны эрчимжүүлсэн кодчлолын хөтөлбөрт хүүхдээ хамруулан оюуны хөрөнгө оруулалт хийж бидний үйл ажиллагааг дэмжсэнд гүнээ талархсанаа дахин илэрхийлье. Хөтөлбөр амжилттай болсон нь бид бүгдийн гурван талт хамтын ажиллагаа байсан гэдгийг дурьдахад таатай байна.



Тим багш нь ярьж байсанчлан бид бүгдийн (магадгүй ихэнхийх нь) алсын зорилго бол хаана ч хүлээн зөвшөөрөгдөх жилийн \$65,636-ын төлбөртэй Карнеги Меллоны их сургуулийн 4 кредитийг (шалгалтаа амжилттай өгсөн тохиолдолд) Монголдоо дунд сургуульд сурч байх явцдаа олж авах боломжтой CPCS хөтөлбөрт амжилттай бэлдэж хамрагдах явдал гэж бодож байна.

Гурван үе шаттай цогц хөтөлбөрөө дахин нэг харцгаавал:

Хөтөлбөр

Тайлбар

Зорилт / Боломж

Статус

CS0: Exploring Programming	• Анхан шат (40 цаг)	АНУ дахь бүтээлч төслийн уралдаанд оролцох	✓
CS1: Introduction to Programming	• Дунд шат (120 цаг) • Бүтэн хичээлийн жил үзэх хөтөлбөр	АНУ дахь бүтээлч төслийн уралдаанд оролцох	
CPCS: College Programming and Computer Science	• Ахисан шат (120 цаг) • Бүтэн хичээлийн жил үзэх хөтөлбөр	Карнеги Меллоны их сургуулийн 4 кредиттэй болох	

Бидний хувьд эхний шатаа амжилттай дүүргэсэн ба энэ хичээлийн жилийн хувьд урт хугацааны CS1 хөтөлбөрт элсэн суралцах боломж бүрдэж байна.



CS1 хөтөлбөрийн тухай

Золбаяр багшийн хувьд уг хөтөлбөрийг 2022-23 оны хичээлийн жилд Монголдоо танхимаар хэрэгжүүлж байсан, одоо зөвхөн онлайнаар АНУ дахь сурагчдад зааж байгаа. Харин энэ жилээс эхлэн Карнеги Меллоны их сургуулийн ахлах курсын оюутнууд болон Тим багштай хамтран онлайн танхим хослосон hybrid сургалтын аргачлалаар заахаар болж байна.

CS1 хөтөлбөр нь нийт 12 бүлэг (unit) хичээлээс бүрдэх ба эхний 6 бүлэгт бидний CS0 ангид сурсан зүйлийг бататган гүнзгийрүүлж үзэх бол дараагийн 6 бүлэгт цоо шинэ сэдвүүдийг үзнэ. Хөтөлбөрийн агуулгын хувьд хүндэрнэ, тийм ч учраас

хичээлийн хажуугаар амжилттай суралцахын тулд **хүүхэд бүр өөрийн суралцах тодорхой хуваарийг гаргаж түүнийгээ ягштал мөрдөх шаардлагатай болно.** CS0-тэй харьцуулахад агуулга, хийх даалгавар хамаагүй их учир нэг хоцорвол гүйцэхэд хэцүү болж суралцаж буй хүүхдэд төдийгүй багшид хичээл явуулахад маш их хүндрэлтэй болдог гэдгийг мөн хэлэх нь зүйтэй байх.

CS1 хөтөлбөр нь CS0 төгсөөгүй хүүхдүүд ч шинээр элсэн суралцах боломжтой. Мөн хэрэв сонирхож байвал эцэг эхчүүд ч суралцах боломжтой!

Хичээллэх хуваарь болон логистик

2025-26 оны хичээлийн жилийн хувьд Яамнаас өмнөх жилийнхтэй адил 3 улиралтай байхаар батлагдсан байгаа. Өвлийн амралтын хувьд дунд ангийн сурагчид 12 сарын 22-оос эхлэн амрах бол ахлах анги 29-өөс эхлэн амрах хуваарьтай байна. Хоёрдугаар улирал 2026 оны 1 сарын 26-аас эхлэх юм.

Ажлын өдрүүдэд: Бидний хувьд өөр өөр сургуульд суралцдаг, өөр өөр хуваарийн хичээлтэй тул ажлын өдрүүдийн түгжрэлд, өвлийн харанхуйд компьютер үүрэн явснаас гэртээ суун Google Meet платформ ашиглан онлайн вебинараар багштайгаа хичээллэх нь илүү тохиромжтой. Бидний хэрэглэж сурсан CMU CS Academy платформ нь тухайн сурагчийн юун дээр ажиллаж байгааг багш хажууд байгаа мэт хянах боломжийг олгодог учраас чанарын хувьд танхимын сургалтаас ялгаагүй байдаг.

Амралтын өдрүүдэд: Бямба гараг хөл хөдөлгөөн ихтэй байдаг учраас Ням гарагийн үдээс хойшхи цагийг ашиглана.

Сургалтын хуваарь товчхондоо:

- Бидний хувьд долоо хоногийн 4 цагаар хичээллэхэд 120 цагийн хичээлийг нийт 30 долоо хоног хичээллэж төгсөх юм.
- Үүнд эхний 6 бүлэг буюу 15 долоо хоногийг (1-р семестер) оноос өмнө, үлдсэн 6 бүлгийг (2-р семестер) оны дараа хичээллэнэ.
- Долоо хоногийн 4 цагийг 3 удаагийн хичээлээр орох ба дараах хуваариар хичээллэнэ:
 - ОНЛАЙН** - Ажлын өдрүүдэд: Мягмар, Пүрэв гарагуудад оройн цагаар 7-8 цагийн хооронд.
 - ТАНХИМ** - Амралтын өдөр: Ням гарагт 4-6 цагийн хооронд.
 - ОРОН НУТГИЙН СУРАГЧДАД:** Танхимын цагийг Ням гарагийн 7-9 цагийн хооронд.
- Үүнд зуны хөтөлбөрийн адилаар Золбаяр багш нь шинэ ойлголтуудаа тайлбарлаж даалгавраа хийлгэх замаар агуулгын хувьд хянаж ажиллах бол Америк багш нар үзсэн сэдвийн дагуу бүтээлч төслүүд хийлгэх хэлбэрээр сардаа 1 удаа хичээл орох төлөвлөгөөтэй байна.

Хичээлийн жилийн календарчилсан төлөвлөгөө

Сар	Долоо хоногууд	Хичээлийн сэдэв
1-р семестер: 2025 оны 9 сарын 16-аас 12 сарын 28 (15 долоо хоног)		

9-p cap	1-р долоо хоног (9 сарын 15)	Unit 1: Creating Drawings
	2-р долоо хоног (9 сарын 22)	Unit 1: Creating Drawings
	3-р долоо хоног (9 сарын 29)	Unit 1: Creating Drawings
10-p cap	4-р долоо хоног (10 сарын 6)	Unit 2: Functions, Mouse Events, and Properties
	5-р долоо хоног (10 сарын 13)	Unit 2: Functions, Mouse Events, and Properties
	6-р долоо хоног (10 сарын 20)	Unit 3: Mouse Motion Events, Conditionals, and Helper Functions
	7-р долоо хоног (10 сарын 27)	Unit 3: Mouse Motion Events, Conditionals, and Helper Functions
11-p cap	8-р долоо хоног (11 сарын 3)	Unit 3: Mouse Motion Events, Conditionals, and Helper Functions
	9-р долоо хоног (11 сарын 10)	Unit 4: More Conditionals, Key Events, and Methods
	10-р долоо хоног (11 сарын 17)	Unit 4: More Conditionals, Key Events, and Methods
	11-р долоо хоног (11 сарын 24)	Unit 5: Complex Conditionals and More Key Events
12-p cap	12-р долоо хоног (12 сарын 1)	Unit 5: Complex Conditionals and More Key Events
	13-р долоо хоног (12 сарын 8)	Unit 6: Groups, Step Events, and Motion
	14-р долоо хоног (12 сарын 15)	Unit 6: Groups, Step Events, and Motion
	15-р долоо хоног (12 сарын 22)	Unit 6: Groups, Step Events, and Motion
Амралт: 2025 оны 12 сарын 29-өөс 2026 оны 1 сарын 25 (4 долоо хоног)		
- Амралтаараа долоо хоногт 1 удаа академи дээрээ биечлэн ирж 1 цагийн давтлага хичээлийг Золбаяр багшаас үнэ төлбөргүй авах боломжтой. Үүнд: - Ойлгоогүй, эсвэл дутуу ойлгосон сэдвүүдээ ганцаарчлан тайлбарлуулах 1-р семестерийн агуулгыг 100% дуусгасан бол нэмэлт бодлого авч бодох - Бие даалтын төслүүд дээрээ зөвлөгөө авах г.м. - Хэрвээ амралтын 4 долоо хоногийн турш нэмэлтээр ганцаарчлан хичээллэх шаардлагатай (эсвэл сонирхолтой) бол тухайн үед багштайгаа холбогдоно уу.		
2-р семестер: 2026 оны 1 сарын 27-оос 5 сарын 10 (15 долоо хоног)		
1-p cap	16-р долоо хоног (1 сарын 26)	Unit 7: New Shapes, Local Variables, and For Loops

2-р сар	17-р долоо хоног (2 сарын 2)	Unit 7: New Shapes, Local Variables, and For Loops
	18-р долоо хоног (2 сарын 9)	Unit 8: Math Functions, Random Values, and Nested Loops
	19-р долоо хоног (2 сарын 16)	Unit 8: Math Functions, Random Values, and Nested Loops
	20-р долоо хоног (2 сарын 23)	Unit 8: Math Functions, Random Values, and Nested Loops
3-р сар	21-р долоо хоног (3 сарын 2)	Unit 9: Types, Strings, and While Loops
	22-р долоо хоног (3 сарын 9)	Unit 9: Types, Strings, and While Loops
	23-р долоо хоног (3 сарын 16)	Unit 10: Lists and Return Values
	24-р долоо хоног (3 сарын 23)	Unit 10: Lists and Return Values
	25-р долоо хоног (3 сарын 30)	Unit 11: 2D Lists and Board Games
4-р сар	26-р долоо хоног (4 сарын 6)	Unit 11: 2D Lists and Board Games
	27-р долоо хоног (4 сарын 13)	Unit 12: Final Project
	28-р долоо хоног (4 сарын 20)	Unit 12: Final Project
	29-р долоо хоног (4 сарын 27)	Unit 12: Final Project
5-р сар	30-р долоо хоног (5 сарын 4)	Unit 12: Final Project

Тэмдэглэлт өдрүүд

Kick-off Meeting: 2025 оны 9 сарын 14-нд 4:00 цагаас [Академи дээрээ]

Эцэг эхийн хурал: 2026 оны 1 сарын 4-нд 4:00 цагаас [Онлайнаар]

Төгсөлтийн эвент: 2026 оны 5 сарын 10-нд 4:00 цагаас [Академи дээрээ]

Төлбөрийн нөхцөл

- Хөнгөлөлт 1: Зуны хөтөлбөрт оролцсон бүх сурагчдад хөтөлбөрийн нийт төлбөр болох ₮2'650'000-аас ₮50K хөнгөлөлт үзүүлж байна.
- Хөнгөлөлт 2: 9 сарын 15-ны дотор буюу сургалт эхлэхээс өмнө төлбөрийг 100% төлөх тохиолдолд 10%-ийн төлбөрийн хөнгөлөлтийг үзүүлж жилийн нийт төлбөр:

- Зуны хөтөлбөрт суусан (эсвэл өмнө нь сурч байсан) бол ₮2'340'000
- Анх удаагаа сурч байгаа бол ₮2'385'000 болох юм.
- Хөнгөлөлт 3: Нэг айлын 2 хүүхэд сурах бол нийт төлбөрөөс 10% хөнгөлнө.

Бүртгэл

Дараах формыг бөглөж суудлаа баталгаажуулна уу:

<https://forms.gle/qV5J4qpztL8wmNm7A>

